



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/72

Мөрөн сум

Нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн  
мөнгийг буцаан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн санд 2021 оны жилийн эцэст нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 57,846,118 (тавин долоон сая найман зуун дөчин зургаан мянга нэг зуун арван найм) төгрөг, Соёл урлагийн газрын 15,000,000 (арван таван сая) төгрөгийг тухайн байгууллагуудад буцаан олгосугай.

2. Хөгжимт драмын театрын 2,130 (хоёр мянга нэг зуун гуч) төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын 31,241 (гучин нэгэн мянга хоёр зуун дөчин нэг) төгрөг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 5,500 (таван мянга таван зуу) төгрөгийг тус тус аймгийн орлогод тооцсугай.

3. Байгууллагуудын нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн 72,846,118 (далан хоёр сая найман зуун дөчин зургаан мянга нэг зуун арван найм) төгрөгийг буцаан олгож, 38,871 (гучин найман мянга найман зуун далан нэг) төгрөгийг аймгийн ерөнхий орлогын дансанд шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Гантулга) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН